



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 48

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит VI хуралдааныг 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулсугай

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VI хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Гурав. Хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Мөнхбатад даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ